



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өргөн сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2021/51/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ч.Ариунаа

Утас: 70523020

Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ОНТ	Орон Нутгийн Төсөв
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
ХАБ	Хөдөлмөрийн Аюулгүй Байдал
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан .....	14
3.1.Ерөнхий зүйл .....	12
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	15
3.4.Материаллаг байдал .....	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7.Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9.Аудитын илрүүлэлт .....	18
Залруулсан алдаа .....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж .....	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	18
4.Менежментийн захидал .....	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn	<b>ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА О.ЦАСАНЦЭЦЭГ ТАНАА</b>
2021.02.04 № 16/88	
танай _____-ны № _____-г	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өргөн сумын Засаг даргын тамгын газрын дарга 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Бусад мэдээлэл</b>	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,182,944.83	148,533,424.83
33	АВЛАГА	8,940,314.00	5,397,314.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	81,600.00	-
335	Бусад авлага	8,858,714.00	5,397,314.00
3351	Байгууллагаас авах авлага	2,544,400.00	4,583,100.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,314,314.00	814,214.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,242,630.83	143,136,110.83
351	Түүхий эд материал	-	228,400.00
35110	Тусгай зориулалттай материал	-	228,400.00
354	Хангамжийн материал	84,549,590.83	87,439,670.83
35410	Бичиг хэргийн материал	663,860.00	815,960.00
35420	Аж ахуйн материал	83,230,610.83	86,623,710.83
35450	Барилгын засварын материал	655,120.00	-
35600	Мал амьтад	52,693,040.00	55,468,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,728,176,026.30	1,714,867,630.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,728,176,026.30	1,714,867,630.98
392	Биет хөрөнгө	1,658,197,047.28	1,642,757,714.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	966,631,384.00	966,631,384.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,610,225.32)	(70,201,477.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	359,308,400.00	425,508,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(273,715,957.69)	(273,786,482.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,844,504.48	99,783,183.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,702,225.34)	(57,668,807.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,218,871.92	38,130,613.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,915,457.89)	(29,066,045.51)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	8,005.69	8,005.69
39212	Хуримтлагдсан элэгдэл	(8,005.69)	(8,005.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,021,982,832.13	1,032,282,832.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(428,684,429.01)	(489,695,235.93)
39217	Ном	839,350.00	839,350.00
393	Биет бус хөрөнгө	69,978,979.02	72,109,916.45
39301	Програм хангамж	3,671,000.00	6,157,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,034,020.98)	(3,389,083.55)
39303	Бусад биет бус хөрөнгө	69,342,000.00	69,342,000.00
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,874,358,971.13	1,863,401,055.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,045,595.90	634,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,045,595.90	634,600.00
413	Өглөг	4,045,595.90	634,600.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	150,000.00	150,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,849,095.90	481,000.00
4136	Бусад өглөг	46,500.00	3,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	34,000.00	-

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,500.00	3,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,870,313,375.23	1,862,766,455.81
51	Засгийн газрын хувь оролцоо	1,870,313,375.23	1,862,766,455.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	839,615,463.96	839,615,463.96
512	Хуримтлагдсан үр дүн	627,295,801.77	619,748,882.35
51210	Өмнөх үеийн үр дүн	627,295,801.77	627,295,801.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,546,919.42)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	403,402,109.50	403,402,109.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,874,358,971.13	1,863,401,055.81

## 2.2 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	620,935,522.00	551,735,172.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	198,347,268.00	135,959,402.60
120	Нийтлэг татварын бус орлого	198,347,268.00	135,959,402.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	198,347,268.00	135,959,402.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,737,500.00	3,400,331.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ		120,650,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ		11,909,071.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	192,609,768.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,588,254.00	415,775,770.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,880,154.00	31,620,555.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,547,717.00	10,367,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,332,437.00	21,253,555.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,708,100.00	384,155,215.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,708,100.00	384,155,215.21
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	486,137,535.31	542,409,044.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,137,535.31	542,409,044.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,799,498.78	531,885,767.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,405,706.35	253,148,456.45
210101	Үндсэн цалин	206,405,706.35	225,805,388.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,091,216.58
210104	Урамшуулал	-	19,251,851.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,290,200.00	30,824,720.80
210201	Тэтгэврийн даатгал	18,344,000.00	19,561,881.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,986,600.00	2,814,559.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,589,300.00	2,252,527.76
210204	Ажилгүйдлийн даатгал	397,300.00	565,431.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,973,000.00	5,630,319.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,737,896.09	34,456,533.58
210301	Гэрэл, цахилгаан	5,177,237.19	4,977,979.58
210302	Түлш, халаалт	25,407,363.90	26,934,530.00

210303	Цэвэр, бохир ус	2,153,295.00	2,544,024.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,609,221.00	24,178,400.00
210401	Бичиг хэрэг	6,225,521.00	3,515,400.00
210402	Тээвэр, шатахуун	21,551,090.00	14,046,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,891,382.00	2,748,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	142,080.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,799,148.00	3,748,530.00
2105	Нормативт зардал	-	1,360,000.00
210502	Хоол, хүнс	-	1,360,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,742,160.00	3,105,984.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300.00	-
210604	Урсгал засвар	1,741,860.00	3,105,984.00
2107	Томилолт, зочны зардал	4,036,600.00	2,111,600.00
210702	Дотоод албан томилолт	4,036,600.00	2,111,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,636,644.00	51,402,125.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,597,715.00	48,645,112.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,974.00	1,127,789.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	417,446.00	230,000.00
210807	Газрын төлбөр	154,679.00	129,224.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,341,071.34	131,297,947.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	7,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,275,340.00	1,195,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	146,065,731.34	123,102,947.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,338,036.53	10,523,276.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,593,700.00	6,788,502.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,593,700.00	6,788,502.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,744,336.53	3,734,774.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,744,336.53	3,734,774.48
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,888,586.00	29,368.74
2200	Дотоод эх үүсвэрээр	45,888,586.00	29,368.74
222001	Тоног төхөөрөмж	-	29,368.74
223001	Бусад хөрөнгө	45,888,586.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,909,400.69	9,296,759.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	16,843,679.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,936,590.63
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	780,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал- ҮХ	-	10,583,688.64
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-БМ	-	1,543,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(16,843,679.27)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,909,400.69	(7,546,919.42)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	425,461,754.00	425,896,601.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,873,500.00	5,042,831.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,873,500.00	5,042,831.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,873,500.00	5,042,831.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,873,500.00	5,042,831.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,588,254.00	420,853,770.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,880,154.00	36,698,555.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,547,717.00	10,367,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,332,437.00	26,331,555.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,708,100.00	384,155,215.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,708,100.00	384,155,215.21
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	409,188,268.00	421,059,001.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,188,268.00	421,059,001.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	401,700,731.47	407,757,624.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,282,196.28	252,887,986.45
210101	Үндсэн цалин	207,282,196.28	225,544,918.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,091,216.58
210104	Урамшуулал	-	19,251,851.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,090,200.00	30,824,720.80
210201	Тэтгэврийн даатгал	18,344,000.00	19,561,881.79
210202	Тэтгэмжийн даатгал	1,986,600.00	2,814,559.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,589,300.00	2,252,527.76
210204	Ажилгүйдлийн даатгал	397,300.00	565,431.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,973,000.00	5,630,319.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,857,099.19	37,888,375.48
210301	Гэрэл, цахилгаан	5,177,237.19	4,977,979.58
210302	Түлш, халаалт	20,886,856.00	30,288,871.90
210303	Цэвэр, бохир ус	3,793,006.00	2,621,524.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,472,259.00	21,409,870.00
210401	Бичиг хэрэг	3,978,621.00	3,515,400.00
210402	Тээвэр, шатахуун	13,830,256.00	14,026,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,891,382.00	2,748,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,652,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	200,000.00	1,560,000.00

210502	Хоол, хүнс	-	1,360,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,540,100.00	3,523,364.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,215,100.00	346,300.00
210602	Тавилга	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	825,000.00	3,177,064.00
2107	Томилолт, зочны зардал	4,036,600.00	2,111,600.00
210702	Дотоод албан томилолт	4,036,600.00	2,111,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,323,007.00	46,342,708.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,284,078.00	43,585,695.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	368,920.00	550,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,974.00	1,127,789.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	174,356.00	230,000.00
210807	Газрын төлбөр	154,679.00	129,224.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,899,270.00	11,209,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	9,420,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,899,270.00	1,789,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,487,536.53	13,301,376.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,300,000.00	6,788,502.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	6,788,502.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,744,336.53	6,512,874.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,744,336.53	3,734,774.48
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,778,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,443,200.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,443,200.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	52,073,486.00	4,837,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,073,486.00	4,837,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,073,486.00	4,837,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,073,486.00	4,837,600.00
223001	Бусад хөрөнгө	45,888,586.00	4,837,600.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	6,184,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(52,073,486.00)	(4,837,600.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	839,615,463.96	403,402,109.50	544,156,488.08	1,787,174,061.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>839,615,463.96</b>	<b>403,402,109.50</b>	<b>627,295,801.77</b>	1,870,313,375.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>839,615,463.96</b>	<b>403,402,109.50</b>	<b>627,295,801.77</b>	1,870,313,375.23
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>839,615,463.96</b>	<b>403,402,109.50</b>	<b>627,295,801.77</b>	1,870,313,375.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>839,615,463.96</b>	<b>403,402,109.50</b>	<b>627,295,801.77</b>	1,870,313,375.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,546,919.42)	(7,546,919.42)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>839,615,463.96</b>	<b>403,402,109.50</b>	<b>619,748,882.35</b>	1,862,766,455.81

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	393,058,200.00	389,198,046.21	3,860,153.79	99.02
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	393,058,200.00	389,198,046.21	3,860,153.79	99.02
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	386,258,200.00	378,674,769.73	7,583,430.27	98.04
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	253,529,500.00	252,887,986.45	641,513.55	99.75
210101	Үндсэн цалин	224,691,100.00	225,544,918.87	(853,818.87)	100.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,769,000.00	8,091,216.58	677,783.42	92.27
210104	Урамшуулал	20,069,400.00	19,251,851.00	817,549.00	95.93
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,441,700.00	30,824,720.80	1,616,979.20	95.02
210201	Тэтгэврийн даатгал	22,266,000.00	19,561,881.79	2,704,118.21	87.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,543,400.00	2,814,559.78	(271,159.78)	110.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,035,600.00	2,252,527.76	(216,927.76)	110.66
210204	Ажилгүйдлийн даатгал	508,900.00	565,431.96	(56,531.96)	111.11
210205	Эрүүл мэндийн даатгал	5,087,800.00	5,630,319.51	(542,519.51)	110.66
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,129,100.00	37,888,375.48	4,240,724.52	89.93

210301	Гэрэл, цахилгаан	5,203,300.00	4,977,979.58	225,320.42	95.67
210302	Түлш, халаалт	33,897,800.00	30,288,871.90	3,608,928.10	89.35
210303	Цэвэр, бохир ус	3,028,000.00	2,621,524.00	406,476.00	86.58
2104	Хангамж, бараа материалын зардал	19,353,600.00	19,208,200.00	145,400.00	99.25
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	3,305,400.00	145,400.00	95.79
210402	Тээвэр, шатахуун	12,178,800.00	12,178,800.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,604,000.00	2,604,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,280,000.00	6,830,964.00	449,036.00	93.83
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
210602	Тавилга	1,300,000.00	1,253,900.00	46,100.00	96.45
210604	Урсгал засвар	3,580,000.00	3,177,064.00	402,936.00	88.74
2107	Томилолт, зочны зардал	2,220,900.00	2,111,600.00	109,300.00	95.08
210702	Дотоод албан томилолт	2,220,900.00	2,111,600.00	109,300.00	95.08
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,203,400.00	21,933,923.00	269,477.00	98.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,197,000.00	19,176,910.00	20,090.00	99.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	550,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,276,400.00	1,127,789.00	148,611.00	88.36
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	230,000.00	230,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	230,000.00	129,224.00	100,776.00	56.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,789,000.00	111,000.00	98.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,789,000.00	111,000.00	94.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,800,000.00	6,788,502.00	11,498.00	99.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,800,000.00	6,788,502.00	11,498.00	99.83
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,800,000.00	6,788,502.00	11,498.00	99.83
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>393,058,200.00</b>	<b>389,198,046.21</b>	<b>3,860,153.79</b>	<b>99.02</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>389,558,200.00</b>	<b>384,155,215.21</b>	<b>5,402,984.79</b>	<b>98.61</b>
132001	Орон нутгийн төсвөөс	389,558,200.00	384,155,215.21	5,402,984.79	98.61
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,500,000.00</b>	<b>5,042,831.00</b>	<b>(1,542,831.00)</b>	<b>144.08</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	5,042,831.00	(1,542,831.00)	144.08
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25.00</b>	<b>22.00</b>	<b>3.00</b>	<b>88</b>
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	7.00	3.00	70
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100

### **3 Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өргөн сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг О.Цасанцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, үндсэн болон туслах үйл ажиллагаа, орлогын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.01.25-аас 2021.01.27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.01.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Өргөн сумын ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ны өдрийн 6/45 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өргөн сумын ЗДТГ нь “Сум багийн ажлыг уялдуулан оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, улмаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд чиглэгдэнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого,

журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өргөн сумын ЗДТГ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт зардал 547,155.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,471.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өргөн сумын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,957.9 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	8,940.3	5,397.3	-3,543.0
Урьдчилгаа			
Бараа материал	137,242.6	143,136.1	5,893.5
Үндсэн хөрөнгө	1,728,176.0	1,714,867.6	-13,308.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,874,358.9</b>	<b>1,863,401.0</b>	<b>-10,957.9</b>
Өр төлбөр	4,045.6	634.6	-3,411.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,870,313.4	1,862,766.4	7,547.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,874,358.9</b>	<b>1,863,401.0</b>	<b>-10,957.9</b>

Авлага дансны үлдэгдэл 5397.3 мянган төгрөг болж 3543.0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүнээс авах авлага буурсан нь шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 143,136.1 мянган төгрөг болж 5,893.5 мянган төгрөгөөр өссөн нь хангамж, аж ахуйн материалын үлдэгдэл, мөн малыг нас дэвшүүлэн бүртгэсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,714,867.6 мянган төгрөг болж 13,308.4 төгрөгөөр буурсан нь 11,951.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан нь голлон нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн дансанд ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 120,474.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,837.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 176.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 634.6 мянган төгрөг болж 3,411.0 мянган төгрөгөөр буурсан нь түлш халаалт, тээвэр шатахууны өглөгийг барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,862,766.4 мянган төгрөг болж 7,547.0 төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан нь нөлөөлжээ.

Өргөн сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,812.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 56,271.5 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 327,822.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 327,822.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,235.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 393,058.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 393,058.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 389,558.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 3,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 389,198.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,042.8 мянган төгрөг, нийт 384,155.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 389,198.0 мянган төгрөгийг зарцуулж 3,734.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 389,198.0 мянган төгрөг буюу 99.02 хувьтай байгаа нь урсгал зардлыг 3,734.7 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 10,367.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26,331.5 мянга, нийт 36,698.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 33,920.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,778.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 14 мэдээллээс хугацаандаа оруулсан 14 мэдээлэл байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,558.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3354.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,558.9	1	956.9	1	602.0	61.4
Албан шаардлага	1	3,354.3	1	3,354.3	-		
Зөвлөмж	1	-	1		-		
Нийт дүн	4	4913.2					

Төлбөрийн актыг тогтоосон хугацаанд барагдуулаагүй албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,824.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,810.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 192.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 4,822.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 450.0 мянган төгрөгийн малын үнэ, 308.0 мянган төгрөгийн төхөөрөмжийн үнийг шууд зардалд бүртгэснийг бараа материалын орлогоор залруулав.
2. Түрээсийн орлогын 50 хувийг өглөгөөр тусгасан бөгөөд 31.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг өглөгөөр нэмж бүртгэсэн
3. Түрээсийн авлага 997.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэснийг залруулах бичилт хийсэн
4. Эд хариуцагч тайлангаа НББ-ээс 986.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залрууллаа
5. Түрээсийн авлага 38.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг авлагаар нэмж бүртгүүлсэн

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

1. Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхцуулж 2 ажилтанд 128.2 мянган төгрөгийг олгосон байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг зөрчиж, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тээврийн хэрэгслийн татварын зардлаас 64.0 мянган төгрөгийн торгууль төлсөн байгаа нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчсөн мөн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Засаг даргын орлогчид ХАБ-ын ажилтны ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 30 хувиар тооцож нийт 2,822.6 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Байгууллагын урсгал засварын зардлаас сумын нийтийн эзэмшлийн хөрөнгө хөшөөг засварласан, ЗДНХ-өөс иргэний эмчилгээний зардалд буцалтгүй тусламж үзүүлсэн, үндсэн цалингийн зардлаас хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн НДШ төлсөн зэрэг нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчсөн мөн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Өмнөх онд 1558.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 61.4 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 602.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэх

6. Үндсэн цалингийн зардлаас хүүхэд асрах чөлөөтэй 2 ажилтны НДШ төлсөн

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

#### 4.1.1 Илрүүлэлт

Түрээсийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн, туслах үйл ажиллагаанаас орох ноолуур, эцэг малын түрээсийн орлогыг тус тус төлөвлөөгүй байна.

#### 4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна, Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

#### 4.1.3 Зөвлөмж

Төсвийн төсөлд үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг бүрэн төлөвлөж, батлуулах

### 4.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

#### 4.2.1 Илрүүлэлт

Нийт 11951.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан боловч устгалын баримт үйлдээгүй байна.

#### 4.2.2 Эрсдэл

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Аймгийн ИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолын 7.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

#### 4.2.3 Зөвлөмж

Үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарсны дараа байгууллагын даргын шийдвэрээр өмч хамгаалах комиссыг оролцуулсан устгалын комисс томилон ажиллуулж байх

#### 4.3 Орлогын данстай холбоотой асуудал

##### 4.3.1 Илрүүлэлт

Туслах аж ахуйгаас 1,000.0 мянган төгрөгийн ноолуурын орлого орсон бөгөөд бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо бодоогүй, үр дүнг шийдвэрлээгүй байна.

##### 4.3.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт тус тус зөрчсөн байна.

##### 4.3.3 Зөвлөмж

Төсөв захирагч малчинтай байгуулсан гэрээг дүгнэх, нягтлан бодогч туслах аж ахуйгаас орох орлогын тооцоо хийж, үр дүнг тухай бүр шийдвэрлэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Өргөн сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ДГА-2021/51/СТА- ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Өргөн сумын ЗДТГ</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Түрээсийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн, туслах үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй	-	Зөвлөмж	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
2	Засаг даргын орлогчид хавсран ажилласны нэмэгдэл 30 хувь олгосон	2,822.6	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг
3	Байгууллагын урсгал засварын зардлаас сумын нийтийн эзэмшлийн хөрөнгө хөшөөг засварласан, ЗДНХ-өөс иргэний эмчилгээний зардалд буцалтгүй тусламж үзүүлсэн.	1,196.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг
4	Ээлжийн амралтын олговрыг 2 ажилтанд давхар олгосон.	128.2	Төлбөрийн акт	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
5	Тээврийн хэрэгслийн татварын зардлаас жолоочийн торгууль төлсөн.	64.0	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг
6	Нийт 11951.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан боловч устгалын баримт үйлдээгүй	-	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг
7	Туслах аж ахуйгаас орсон орлогын тооцоо бодоогүй.	1000.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
8	Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 450.0 мянган төгрөгийн малын үнэ, 308.0 мянган төгрөгийн төхөөрөмжийн үнийг шууд зардалд бүртгэснийг бараа материалын орлогоор залруулав	758.0	Залруулсан	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
9	Түрээсийн орлогын 50 хувийг өглөгөөр тусгасан бөгөөд 31.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг өглөгөөр нэмж бүртгэсэн	31.0	Залруулсан	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
10	Түрээсийн авлага 997.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэснийг залруулах бичилт хийсэн	997.0	Залруулсан	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
11	Эд хариуцагч тайлангаа НББ-ээс 986.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залрууллаа	986.2	Залруулсан	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
12	Түрээсийн авлага 38.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг авлагаар нэмж бүртгүүлсэн	38.0	Залруулсан	Нягтлан бодогч	М.Отгонтөгс
13	Өмнөх онд 1558.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 61.4 хувьтай байна. Төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй 602.0 мянган төгрөгийн зөрчил байна.	-	Хариуцлага тооцуулах	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг

13	Үндсэн цалингийн зардлаас хүүхэд асрах чөлөөтэй 2 ажилтны НДШ төлсөн	803.5	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга	О.Цасанцэцэг
<b>ДҮН</b>		<b>8,824.5</b>			